

**“САВ, БАГЛАА БООДОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2019 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1.	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр нь Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан.	Хөтөлбөрийн зорилго: Сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	- улсын болон орон нутгийн төсөв; - гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж; - хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн эх үүсвэр; - гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт; - бусад эх үүсвэр.
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хөтөлбөр нь 2017-2021 онд хэрэгжинэ. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, БОАЖЯ, МХЕГ, СХЗГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоод, ТББ.
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Хөтөлбөрийн хүрээнд 3 зорилт дэвшүүлсэн. Зорилт 1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүйн болон бизнесийн таатай таатай орчныг бүрдүүлэх; Зорилт 2. Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах; Зорилт 3. Сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх.
5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал) - Үүнд: Төсөв /2019/ Гүйцэтгэл Хувь Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /сая төг/ 10.0 10.0 100.0
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт: Зорилт 1 Зорилт 2 Зорилт 3	Арга хэмжээний биелэлт: Хөтөлбөрийн 3 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 29 үйл ажиллагаа төлөвлөгдсөн. Хавсралтын 1-3 дугаар хуудас Хавсралтын 3-11 дүгээр хуудас Хавсралтын 12-14 дүгээр хуудас
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Ололт: Улс орон даяар “Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөний дүн өрнүүлж, хуванцар савны хүнсний аюулгүй байдалд нөлөөлөх аюулын талаар хот хөдөөгийн хүн амд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэсэн. Дутагдал: Хэрэгжилт хангалтгүй: Засгийн газрын тогтоолоор батлагдснаас хойш 5 жилдээ хэрэгжиж буй уг төслийн хэрэгжилт хангалтгүй буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн нь хангалтгүй үзүүлэлт юм. Тайлагналт хангалтгүй: Хөтөлбөрийг ЭМЯ, БОАЖЯ, МХЕГ, СХЗГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоод, ТББ зэрэг олон байгууллага хамтран хэрэгжүүлэхээр заасан боловч холбогдох газрууд тайлан ирүүлдэггүй нэгтгэхгүй практик зонхилдог нь тайлан бодитой бус, үр дүнг бус үйл ажиллагааг дараалуулан тоочсон, адил төстэй арга хэмжээний тайлангаар орлуулсан, ирээдүйд болох таамаглал тусгасан байдлаар тайлагнахад хүргэдэг. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш анх удаа орон нутгийн байгууллагуудаас тайлан авсан. Гэвч тайлангийн нэгтгэл

		<p>хийгээгүй, улсын хэмжээний нэгдсэн тоо баримт, судалгаа хийгдээгүй байдалтай байв.</p> <p>Төлөвлөлтийн алдаатай байдал: Дээрх хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө нь Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралт, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан суурь түвшин, суурь он, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг, хүрэх үр дүнг оноор нарийвчлан тусгаагүй байдалтай батлуулсан нь үр дүнгийн өөрчлөлтийг хэмжиж, бодит үнэлгээ өгөх боломж олгохгүй байдалтай.</p> <p>Төсөв хэрэгжүүлэхэд шаардагдах зардалын тооцоо хийгдээгүй. Хөтөлбөрт заасан үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн түвшин тогтоодоггүй:</p> <table border="1" data-bbox="625 772 1455 1167"> <thead> <tr> <th>№</th> <th>Шалгуур үзүүлэлт</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Суурь үзүүлэлт</th> <th>Хүрэх үзүүлэлт</th> <th>Өөрчлөлтийн хувь, %</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Нэг өрхийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хадгалдаг зориулалтын бус хуванцар савны тоо</td> <td>ширхэг</td> <td>3-4</td> <td>1-2</td> <td>-50</td> </tr> <tr> <td>2</td> <td>Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээ, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдлэг бүхий хэрэглэгч</td> <td>хувь</td> <td>22</td> <td>50</td> <td>+28</td> </tr> <tr> <td>3</td> <td>Сав, баглаа боодол, хаяг шошгын дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь</td> <td>хувь</td> <td>30,0</td> <td>50,0</td> <td>+20</td> </tr> <tr> <td>4</td> <td>Хүнд даацын уутны дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь</td> <td>хувь</td> <td>60</td> <td>100</td> <td>+40</td> </tr> </tbody> </table> <p>Шалгуур үзүүлэлт ёсоор нэг өрхийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хадгалдаг зориулалтын бус хуванцар савны тоо 3-4 байснаа үндэсний хөтөлбөр хэрэгжснээр 1-2 болтол буурах ёстой.</p> <p>Санхүүжилт хангалтгүй байдал: -2019 онд үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхэд 10.2 сая төгрөгийн санхүүжилт хийсэн нь хангалтгүй юм. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоолж, санал хүргүүлдэг боловч тусгагддаггүй, хасагдсан үндэслэл тодорхойгүй байдаг.</p> <p>Анхаарах асуудал: Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, газар хоорондын уялдааг сайжруулах, тайлангийн чанар сайжруулах, хөндлөнгийн үнэлгээнд шаардагдах төсөв тусгах.</p>	№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Хүрэх үзүүлэлт	Өөрчлөлтийн хувь, %	1	Нэг өрхийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хадгалдаг зориулалтын бус хуванцар савны тоо	ширхэг	3-4	1-2	-50	2	Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээ, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдлэг бүхий хэрэглэгч	хувь	22	50	+28	3	Сав, баглаа боодол, хаяг шошгын дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь	хувь	30,0	50,0	+20	4	Хүнд даацын уутны дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь	хувь	60	100	+40
№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Хүрэх үзүүлэлт	Өөрчлөлтийн хувь, %																											
1	Нэг өрхийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хадгалдаг зориулалтын бус хуванцар савны тоо	ширхэг	3-4	1-2	-50																											
2	Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээ, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдлэг бүхий хэрэглэгч	хувь	22	50	+28																											
3	Сав, баглаа боодол, хаяг шошгын дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь	хувь	30,0	50,0	+20																											
4	Хүнд даацын уутны дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь	хувь	60	100	+40																											
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас уг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэж, төсөвт зардал тусгуулах санал сүүлийн 2 жил дараалан хүргүүлсэн боловч шийдэгдэхгүй хасагдсан болно.																														
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	<table border="1" data-bbox="833 1780 1471 1854"> <tr> <td>Зорилт</td> <td>1</td> <td>2</td> <td>3</td> </tr> <tr> <td>Дундаж үнэлгээ</td> <td>69.0%</td> <td>66.0</td> <td>66.3</td> </tr> <tr> <td>Нэгдсэн үнэлгээ</td> <td colspan="3">-</td> </tr> </table>	Зорилт	1	2	3	Дундаж үнэлгээ	69.0%	66.0	66.3	Нэгдсэн үнэлгээ	-																				
Зорилт	1	2	3																													
Дундаж үнэлгээ	69.0%	66.0	66.3																													
Нэгдсэн үнэлгээ	-																															
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	-																														